



V34
175

УЛААНБААТАР

хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1969 оны 3-р сарын 20 ны өдөр

Дугаар 89.

Улаанбаатар хот

ТЗ-ий 1990 140

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.

~~Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас
ТОГТООХ нь:~~

~~Улаанбаатар хотын захиргааны харьяа гадаадын мэрэг-
жилтнийг үйлчлэх газар, нүүдлийн киноны захиргааны дүрмийг
тус тус баталсугай.~~



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА

Д. ЦЭДЭВ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д. ДАМДИНСҮРЭН

1035

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх
Захиргааны 1969 оны 3-р сарын 20-ны
өдрийн 89-р тогтоолоор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН НҮҮДЛИЙН КИНОНЫ
ЗАХИРГААНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл.

1. Улаанбаатар хотын нүүдлийн киноны захиргааны үндсэн үзэсрэлт нь хотын хөдөлмөрчдийг нүүдлийн кино урлагаар байнга үйлчилэхэд оршино.

2. Хотын нүүдлийн киноны захиргаа нь АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа болон түүний соёлын хэлтсийн шууд удирдлага, дээд байгууллагын баталсан хууль, дүрэм, тогтоол заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

3. Хотын нүүдлийн киноны захиргааг байгуулах болон татан буулгахыг Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа шийдвэрлэнэ.

4. Хотын нүүдлийн киноны захиргааг хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны соёлын хэлтсийн даргын тушаалаар томилогдсон дарга удирдана.

5. Хотын нүүдлийн киноны захиргаа нь аж ахуйн тооцоон дээр ажиллах бөгөөд улсын банкинд тусгай харилцах данстай хуулийн этгээд мөн.

6. Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны харьяа нүүдлийн киноны захиргаа гэсэн тэмдэг ба нүүрийг албан хэрэгтэй хэрэглэнэ.

Хоёр. Нүүдлийн киноны захиргааны эрх.

7. Нүүдлийн киноны захиргаа нь өөрийн мэдлийн ажилтан, ажилчдын ажил үүргийг хувиарлан тогтоохын хамт ажилд авах, чөлөөлөх.

8. Нүүдлийн киноны захиргаа нь улсын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд бусад байгууллагуудтай биеэ дааж гэрээ хэлэлцээ байгууллана.

9. Нүүдлийн киноны захиргаа нь кино үйлчилгээний ажлын талаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, Соёлын яам, Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны тогтоол, шийдвэрийг биелүүлэхийн тулд тушаал гаргана.

Гурав. Нүүдлийн киноны захиргааны үүрэг.

10. Хотын нүүдлийн киноны захиргаа нь улсаас өгсөн үзвэр үйлчилгээ улирлын төлөвлөгөөг хугацаанд нь чанартай биелүүлнэ.

11. Нүүдлийн киноны ажилчдын ажлын хариуцлага, сахилга бэл хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагыг ажидаа байнга нэвтрүүлэнэ.

12. Кино үзвэрийн цэгүүдийг өргөтгөх, үйлчилгээний соёлжилтийг байнга сайжруулах арга хэмжээ авна.

13. Кино үзвэрийн машина аппарат тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, ашиглалт байнга сайжруулах арга хэмжээ авч байна.

14. Өөрийн байгууллагын амилд дотоодын хяналт шалгалт сайжруулах ажлыг зохионо.

Дөрөв. хөрөнгө.

15. Нүүдлийн киноны захиргаа нь үзвэр үйлчилгээ санхүүгийн төлөвлөгөөгөөр батлагдсан хөрөнгө, даргын мэдлийн фондтой байна.